

МОНГОЛЫН ОРЧУУЛГЫН ОНОЛ СУДАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОНЦЛОГ

Б.Энхбаяр²⁰

Abstract: *In the paper the author focuses on the current situation of translation studies in Mongolia. She tries to compare studies made in translation theory in the XX century with the situation of translation studies at the beginning of the XXI century. The specific features of translation studies at the beginning of XXI century or from 2000 up to 2015 years in Mongolia reside in that 1. studies have been started to be made in translations of all spheres of life; 2. except Russian, some Oriental and Western languages started to be involved in studies; 3. comparing to previous period, young generation of scholars have been involved in translation studies.*

Түлхүүр үг: *Орчуулга, орчуулгын онол, судалгаа, орчуулгын онцлог, чиглэл, төрөл*

Монголын гүүш эрдэмтэд зөвхөн орчуулга хийгээд зогсохгүй орчуулгын онол, зарчим, чанарын асуудалд анхаарлаа хандуулж судалсаар иржээ. Орчуулгын үүсэл хөгжлийг хүн төрөлхтөн үүссэн цаг үетэй холбож үздэг бол орчуулгын онолыг зарим судлаачид харьцангуй хожуу буюу ХХ зууны 2-р хагасаас эхлэлтэй гэж үздэг. Тэгвэл нүүдэлчин монголчуудын хувьд орчуулгын онол зарчмын асуудлыг тэртээ дундад зууны үеэс, тухайлбал, XVIII зууны үеэс нухацтай авч үзэж байсан байна. Үүний баталгаа нь монголын эрдэмтэн гүүш орчуулагчид хамтын хүч хөдөлмөрөөрөө бүтээсэн “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг” хэмээх нэр томъёоны толь бичиг юм.

Энэхүү толь бичгийг эртний их хөлгөн судар “Ганжуур”-ыг орчуулсны дараа газар газрын гүүш орчуулагчдын оноосон нэр томъёо харилцан адилгүй байсныг жигдлэх зорилгоор зохиосон бөгөөд “Данжуур”-т орсон судруудаа орчуулах болон ариутган шүүхдээ энэхүү нэр томъёоны толь бичгээ баримталжээ.

Энэ нь зөвхөн нэр томъёо жагсаасан толь бичиг төдийгүй ард нь орчуулгын ерөнхий зарчим, орчуулгын үгсийн сангийн асуудал, орчуулгын найруулга зүй зэрэг орчуулгын онолын асуудлыг тайлбарлахын зэрэгцээ орчуулагч хүнд тавигдах шаардлагын асуудлыг ч тодорхой хөндөн авч үзсэнээрээ онцлог учраас Монголын орчуулгын онолын судалгааны эхлэл болсон гэж үзэх бүрэн үндэстэй.

Монголын гүүш эрдэмтдийг “Мэргэд гарахын орон” нэрт энэхүү толь бичиг туурвихад хүргэсэн “Ганжуур, “Данжуур” хөлгөн судрууд нь тухайн үеийн Монголын

²⁰ МУИС, ШУС, зөвлөх профессор, доктор

гүүш орчуулагч эрдэмтдийн чадал чансааг харуулж дэлхийн соёлын өвд багтсан бүтээлүүд билээ. Энэ тухайд 1927 онд Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Дандаа Шансан бээр "... арваад жилийн богино болзоонд орчуулан туурвиж чадсаныг санахул Ар, Өвөр Монголын аль ч нутагт эрдэмтэн мэргэд элбэг байсан нь илэрхий бөгөөд тэдгээр гүүш нар бол чухам алтны доторхи шижир алт, сувдны доторхи гэрэлт сувд мэт сайхан, эрдэм чадал төгс их хэлмэрчид байсан ажгуу."²¹ хэмээн бахдан дурссан байдаг нь нэгийг өгүүлнэ.

XX зуун бол манай орчуулгын онол судлалын хүрээнд ихээхэн амжилт авчирсан үе юм. Орчуулгын онолын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж анхдагч болсон эрдэмтэд хэмээвээс билгүүн их номч Бямбын Ринчен, ардын уран зохиолч Цэндийн Дамдинсүрэн нарыг зүй ёсоор нэрлэнэ. Эрдэмтэн Ц.Дамдинсүрэн 1933 онд "Хичээл билгээ гаргаж, хэл бичгээ хөгжүүлэе" гэдэг өгүүллээрээ "Мэргэд гарахын орон даяг"-ийн үзэл баримтлалын дагуу тухайн үеийн тулгамдсан асуудал болох орчуулгад гадаад үгийг хэрхэн орчуулах ерөнхий зарчмыг гарган монгол хэлний үгийн сангийн баялаг нөөцийг ашиглахын оронд гадаад үгийг бэлэнчлэн зээлдэх нь жирийн хүмүүс ойлгоход муу нөлөөтэй гэдгийг жишээ баримтаар харуулсан байна. Эх хэлнийхээ үг хэллэг, нэр томъёо байсаар атал харийн үгс хэрэглэж, нэр хаягаа харийн хэлээр бичих явдал өнөө цагт хэт задгайрчээ. Их эрдэмтэн Б.Ринчен 1934 онд "Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай" өгүүлэл нийтлүүлж орчуулгын чанар чансааг сайжруулахын чухлыг цохон тэмдэглээд нэр томъёог оновчтой зөв тогтоох, орчуулгад монгол хэлний бүх нөөцийг бүрэн ашиглах, орчуулгын найруулгад онцгой анхааран дахин дахин хянаж байх нь чухал хэмээн үзжээ. Эрдэмтэн Б.Ринчен харь зохиолыг орчуулахдаа үгэнд баригдалгүйгээр монгол хэлнийхээ яруу тансаг найруулгыг эрхэмлэн утга төгөлдөр, сонсголонтой хөрвүүлдэг байсныг манай уншигчид түүний олон зуун орчуулгаас бэлхнээ мэднэ.

1938 онд эрдэмтэн Ц.Дамдинсүрэн "Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай" гэдэг онол дадлагын шинжтэй том өгүүлэл нийтлүүлсэн нь бүхэл зууны турш орос хэлнээс монгол руу орчуулах ажлын онол арга зүйн цэгцтэй хөтөлбөр болсоор байна. Зохиогч энэхүү өгүүлэлдээ шүлэг орчуулахад өгүүлбэр зүйн хувиргалт хийх зайлшгүй шаардлагатай тухай, үгийг зүй зохистой зөв оноох тухай, хам сэдэв орчуулгад чухал байх тухай зэрэг орчуулагч хүний анхаарвал зохих шалгууруудыг авч үзсэн байна. Түүнчлэн үгийг нэмж хасаж болно, харин утгыг нэмж хасвал гэмтэй, өгүүлбэрт халдаж болно, утгад халдаж болохгүй хэмээсэн нь орчуулгын онолын үнэн зөвийн зарчмыг ойлгомжтой, товч өгүүлсэн, орчуулагч бүрийн эрхэмлэвэл зохих санаа мөн ажээ.

XX зууны эхэн хагаст Монголын орчуулагч, судлаачид олон арван өгүүлэл, шүүмж бичиж орчуулгын сэтгэлгээг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байсан хэдий ч ерөнхийдөө орчуулгын судалгааны хүрээ явцуудуу байсныг тухайн үеийн

²¹ Р.Гүрбазар. "Орчуулгын онол дадлагын үндэс", Улаанбаатар, ШУА-ийн хэл зохиолын хүрээлэн, 1996

судлаачид тэмдэглэсэн байдаг. Шүүмж өгүүлэл нь ихэнхдээ үгийн олон цөөн буюу оносон эсэхийг авч үзсэнээс биш орчуулгын зангилаа асуудлыг нухацтай шүүн хэлэлцэх явдал үгүйлэгдсээр байжээ. Орчуулгын зангилаа асуудлыг нухацтай шүүн хэлэлцэх талаар 1970-аад оноос ахиц гарч С.Галсан, Ц.Цэдэндамба, Д.Дашдаваа, Г.Аким, А.Шархүү, Р.Гүрбазар зэрэг судлаач эрдэмтэд орчуулгын онолын зарим тулгамдсан асуудлыг хөндөж шинэ санаа дэвшүүлэх болсон нь орчуулгын сэтгэлгээнд чухал алхам болсон билээ.

Монголын орчуулгын онолын өнөөгийн байдлыг авч үзэхийн тулд орчуулгын онол хөгжсөн ХХ зуун, нэн ялангуяа, энэ зууны хоёрдугаар хагасын үетэй харьцуулж үзэх нь зүйтэй бөгөөд чингэвээс ололт амжилт, хүрсэн үр дүн болоод доголдол дутагдал нь тодорхой харагдана.

ХХ зууны эцэс буюу 1990-ээд оноос 2000-аад он хүртэлх зурвас үед орчуулгын онолын судалгаа үндсэндээ уналтын байдалд орсон бол 2000-аад оноос эргэж сэргэн судлаачид энэхүү асуудалд анхаарлаа хандуулж эхэлсэн билээ.

Энэхүү харьцуулсан судалгааг залуу судлаач, багш М.Амартайваны²² гаргасан орчуулгын онол дадлагын асуудалтай холбоотой бүтээлийн ном зүйд суурилж хийснээ дурдахын сацуу дараа дараагийн судлаачдад гарын авлага болохуйц судалгааны өргөн хэрэглэгдэхүүнийг эмхлэн олны хүртээл болгосонд нь талархлаа илэрхийлье.

Судлаач М.Амартайван жагсаалтандаа орчуулгын онол, судалгаа, шүүмжтэй холбоотой монголын орчуулга судлаач эрдэмтдийн 750 гаруй өгүүлэл, ном бүтээл, сурах бичиг, эмхэтгэл зэргийг зохиогч, бүтээлийн нэр, хэвлэгдсэн он хугацаатай нь багтаажээ. Цаг хугацааны хувьд ХХ зууны эхэн буюу 1930-аад оноос эхлээд 2015 он дуусах үеийг хамруулжээ. Үүнээс 20-иод нь илтгэл өгүүллийн эмхэтгэлүүд байна. Нийтлэгдсэн 730 өгүүлэл, бүтээлийн 56 нь давхардсан буюу нэг өгүүллийг 2 өөр сэтгүүлд хэвлүүлсэн гэж үзэхээр энэ хугацаанд нийтдээ орчуулгын асуудал хөндсөн 674 өгүүлэл, ном товхимол нийтлэгдсэн байна.

Үүнээс: 354 нь ХХ зуунд буюу 1930-аад оноос 1999 он хүртэлх хугацаанд бичигдсэн байна. Үлдсэн 320 өгүүлэл нь өнөө үе буюу 2000 оноос хойших үед бичигджээ. Өөрөөр хэлбэл, ХХI зууны эхний 15 жил бөгөөд сүүлийн дөрвөн жилийн ном бүтээл энэхүү ном зүйд хамрагдаагүйг тэмдэглэе.

Энэ харьцуулалтаас үзэхэд тоо хэмжээний хувьд өмнөх зууны 40-50 жилд орчуулгын онолын судалгаагаар 354 өгүүлэл бичигдсэн бол, ХХI зууны эхэн буюу сүүлийн 15 жилд 320 өгүүлэл нийтлэгдсэн нь харагдана. Энэ бол их том амжилт, чухал үзүүлэлт, өөрөөр хэлбэл, манай орчуулга судлаачид сүүлийн богино хугацаанд урьдах хагас зууны үетэй дүйцэхүйц хэмжээний судалгаа хийжээ гэж үзэж болохоор байна.

²² М.Амартайван, Олон улсын Улаанбаатар их сургуулийн солонгос хэлний багш. Орчуулгын бүтээлийн ном зүйг эмхэтгэжээ.

Судалгааны бүтээлийн хэлбэр хэмжээний хувьд авч үзвэл дээрх 674 гэсэн тоо нь ихэнхдээ өгүүлэл бөгөөд зөвхөн 43 нь ном, сурах бичиг, гарын авлага байна. Үүнээс 12-ыг нь ХХ зуунд, 31-ийг 2000 оноос хойших хугацаанд нийтлүүлжээ.

Түүнчлэн орчуулгын онол судалгаагаар бакалавр, магистр болон докторын зэрэг горилсон бүтээл нийтдээ 30 байгаагийн зөвхөн 2 нь ХХ зуунд (Бүрнээ.Д, Гүрбазар.Р) хамаарах бол энэ зууны эхний 15 жилд 28 ажил бичигдсэн нь мөн л орчуулгын онолын судалгаа хэрхэн өргөжиж байгааг харуулж буйн илрэл юм.

Мөнхүү ном зүйгээс орчуулгын судалгааны чиглэл, төрөл хэлбэр ч тодорхой харагдаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ХХ зуунд манай орчуулга судлаач эрдэмтэд орчуулгын онолын судалгааны уламжлалт чиглэлүүдийг судлахын сацуу орчуулгын төрөл хэлбэрүүдээр ч нарийн судалгаа хийжээ. Тухайлбал, орчуулгын онолын үндсэн асуудлуудын хувьд:

- Орчуулгын үндсэн зарчим, арга
- Орчуулгын хэл найруулгын асуудлууд
- Орчуулгын чанар, орчуулагчдын чадварын асуудал
- Орчуулгын онолыг хөгжүүлэх
- Орчуулгын хувиргалт
- Орчуулгын түүх, уламжлал зэрэг олон асуудал судалж, Монголын орчуулгын онолын гол цөм асуудлуудыг цэгцэлж тодорхой болгосон нь нийт орчуулагч, орчуулга судлаачид, сонирхогчид болон хэлний багш нарт арга зүйн удирдамж болж өгснийг тэмдэглэмээр байна.

Дээрх үндсэн асуудлуудын зэрэгцээ орчуулгын төрөл хэлбэрүүд, нэн ялангуяа, уран зохиолын орчуулгын төрлөөр ултай судалгаа хийж дараа үеийнхэндээ үлдээсэн нь бахархалтай. Үүнд:

- уран зохиолын орчуулга
- шүлэг яруу найргийн орчуулга
- нэр томъёоны орчуулга
- хэлц үгс, өвөрмөц хэллэгийн орчуулга
- үндэсний онцлог буюу реали үгсийн орчуулга
- нийгэм улс төрийн орчуулга
- орчуулгын шүүмж зэрэг сэдвээр өргөн хүрээтэй судалсан билээ.

Өмнөх зууны Монголын орчуулгын онол судалгааны онцлог нь үндсэндээ монгол, орос хоёр хэлний хоорондын орчуулгын хүрээнд хийгдэж байсан нь тухайн нийгэм болон цаг үетэй холбоотой.

Харин Монголын орчин цагийн (XXI зуун буюу 2000 оноос өнөөг хүртэлх үе) орчуулгын онол судалгааны байдал, онцлогийг авч үзвэл ахмад судлаачдын дээр дурдсан чиглэлүүдийг үргэлжлүүлэн судалж олон зуун өгүүлэл, ном зохиол бичихийн зэрэгцээ энэ салбарын дагнасан хурал семинар олныг зохиож үзэл бодлоо уралдуулан

хэлэлцдэг уламжлал тогтож байгаа нь олзуурхууштай юм. Үүний сацуу орчуулгын онол судалгаагаа шинэ чиглэл, төрлөөр хийдэг болжээ. Тухайлбал:

- шинжлэх ухаан техникийн орчуулга
- уул уурхайн салбарын нэр томъёоны орчуулга
- хууль эрхзүйн нэр томъёо
- дипломат баримт бичгийн орчуулга
- анагаах ухаан, уламжлалт анагаах ухааны нэр томъёоны орчуулга
- дулааны тоног төхөөрөмжийн нэр томъёоны орчуулга
- худалдаа үйлчилгээний салбарын нэр томъёо
- геологи болон гидрогеологийн салбарын нэр томъёо
- бизнесийн нэр томъёо
- мал аж ахуйтай холбоотой үг хэллэгийн орчуулга
- эрчим хүч, барилгын салбарын нэр томъёо
- киноны орчуулга
- машины орчуулга
- аман орчуулга буюу хэлмэрчлэхүйн асуудал
- олон улсын хурлын орчуулга
- жин хэмжээ заасан үгсийг орчуулах асуудал гэх мэтчилэн урд нь судалж

байгаагүй олон шинэ чиглэлээр судалгаа хийж асуудал дэвшүүлэх болсон нь энэхүү харьцангуй богино хугацаанд олсон амжилт гэж үзэхэд хүргэж байна.

Энэ ташрамд онцлон тэмдэглүүштэй хамгийн чухал ололт бол урд нь орчуулгын онолын судалгаа, өмнө дурдсанчлан, их төлөв монгол, орос хэлний хүрээнд хийгдэж байсан бол өнөө цагт дээрх олон чиглэл салбарын орчуулга судлалын асуудлыг өрнө, дорнын олон хэлний хүрээнд хийх болжээ.

Их дээд сургуулиуд болон судалгааны байгууллагууд орчуулгын онол, дадлагын асуудлаар эрдэм шинжилгээний хурал семинар зохион явуулдаг болсон нь мөн нэгэн чухал онцлог гэдгийг дахин дурдая.

МУИС-ийн Олон Улсын Харилцааны Сургуулийн Дипломат орчуулгын тэнхим /хуучнаар/ орчуулгын онол, дадлагын асуудлаар улсын хэмжээний 10, олон улсын хэмжээний 1 хурал зохион байгуулж, тэдгээрт энэ салбарын нэртэй орчуулагчид, онолчид, хэл шинжлэлийн эрдэмтэн профессорууд, орчуулгын хичээл заадаг багш мэргэжилтнүүд оролцдог байсан нь орчуулгын онолын хөгжилд зохих хувь нэмэр оруулснаас гадна орчуулга сонирхогч оюутан залуусын сонирхлыг ихээр татдаг байлаа.

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Орчуулгазүйн профессорын баг санаачлан дээрх хурлуудын үргэлжлэл болгон орчуулгын хурлыг уламжлал болгон зохиож байгаа нь сайшаалтай хэрэг билээ. Тэд нийт 7 удаа хурал зохиосны эхнийх нь орчуулга судлаач, гүүш Г.Аким оролцсон семинар байлаа. Эдгээр хуралд манай туршлагатай орчуулагч, эрдэмтдээс гадна залуу судлаач, багш нар олноор оролцох болсон явдал маш том ололт юм хэмээн үзэж байна.

Түүнчлэн МУБИС, ШУТИС болон МУИС-ийн Ази, Европ болон Их Британи, Америк судлалын тэнхимүүд, Гадаад хэлний сургалтын төв зэрэг дээд боловсролын байгууллагууд хэл шинжлэл, заах аргын асуудлын зэрэгцээ орчуулга судлалаар эрдэм шинжилгээний хурал зохион явуулдаг уламжлалтай болоод байна.

Орчуулгын асуудлаар бие даасан сэтгүүл болон хурлын илтгэл өгүүллийн эмхэтгэлүүд энэ хугацаанд олноор хэвлэгдэж нийтийн хүртээл болоод байна.

Өмнөх зууны үед “Орчуулах эрдэм” нэртэй сэтгүүл 1972-1989 оны хооронд нийт 8 дугаар гарсан байна.

Харин сүүлийн үед МУИС-ийн ОУХС-ийн Дипломат орчуулгын тэнхим орчуулгын хурлуудынхаа үр дүн болгож илтгэл өгүүллийн 11 эмхтгэл, МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Орчуулгазүйн профессорын багийнхан “Орчуулгазүй” нэртэй сэтгүүл 6 дугаар, МУБИС “Гадаад хэл заах арга зүйн асуудал” сэтгүүл 8 дугаар, ШУТИС, Гадаад хэлний институт “Хавсарга хэл шинжлэл” сэтгүүл 12 дугаар гаргажээ.

“Орчуулгын бүтээлийн ном зүй”-д тулгуурлан хийсэн миний энэхүү товч судалгаанаас Монголын орчуулгын судалгааны өнөөгийн төлөв байдал, онцлог болон ХХ зууны орчуулгын судалгаанаас ялгаатай тал ерөнхий дүр төрхөөрөө ойлгогдоно хэмээн найдаж байна. Цаашдын нарийвчилсан судалгааг залуу эрдэмтэн судлаачид маань хийнэ гэдэгт гүнээ итгэж байна.

Эцэст нь дүгнэхэд:

- Өнөө үеийн орчуулгын онолын судалгааны онцлог нь ХХ зуунтай харьцуулахад сэдэв, агуулгын хувьд баяжиж орчуулгын онолын үндсэн асуудлуудыг тал бүрээс нь авч үзсэн олон зуун өгүүлэл бүтээл хэвлэгдэн гарчээ.
- Орчуулгын онолын судалгаа үндсэндээ монгол, орос хэлний хооронд хийгддэг байсан бол орчин үед Өрнө, Дорнын олон хэлний хүрээнд хийгдэх болсон нь Монголын орчуулгын судалгаанд оруулж буй ихээхэн хувь нэмэр, ахиц дэвшил юм.
- ХХ зуунд орчуулгын онолын асуудлаар тоотой хэдэн эрдэмтэн мэргэд судалгаа хийдэг байсан бол өнөө үед орчуулгын онол судлалд залуу судлаачид олноороо түрэн орж ирж урьд өмнө судлагдаагүй сонирхолтой сэдвүүд хөндөн судлах болсон нь “Мэргэд гарахын орон”-оос эхтэй Монголын орчуулгын онол судалгааны уламжлал улам хүрээгээ тэлж өргөжин хөгжиж буйн баталгаа болж байна гэж үзэж болно.

Ном зүй

Эх сурвалж:

Амартайван.М.Орчуулгын бүтээлийн ном зүй, “Орчуулга зүй” цуврал, 2016, №05 (452), 230-268-р тал

Ном, өгүүлэл:

1. Адъяа.О. “Орчуулга: онол, туршлага, сургамж”. УБ, 2008
2. Аким.Г. “Орчуулгын санг уудлахад”. УБ,
3. Гүрбазар.Р “Орчуулгын онол дадлагын үндэс”, Улаанбаатар, ШУА-ийн хэл зохиолын хүрээлэн, 1996
4. Дашдаваа.Д.”Орчуулгын онолын зарим асуудал”.сэтгүүл ”Шинжлэх ухаан амьдрал”, УБ, 1976, №5, 70-73-р тал
5. Чойжил.Д. “Орчуулагчийн жаргал зовлон”. Улаанбаатар, 2006
6. Энхбаяр.Б. “Монголын орчуулгын онол судалгааны асуудлын тухайд”.”Орчуулах эрдэм-3”, илтгэл өгүүллийн эмхтгэл, МУИС, ОУХС, Дипломат орчуулгын тэнхим, УБ, 2011
7. Энхбаяр.Б. “Монголын орчуулгын уламжлалын зарим асуудлыг хөндөхүй”, “Орчуулгазүй-1” цуврал, МУИС, ГХСС, УБ, 2013, 153-158-р тал